

Хурлын тэмдэглэл

“Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Мэдээллийн технологийн үндэсний паркийн 211 тоот хурлын танхимд 15:00-17:00 цагийн хооронд болов.

Хуралд оролцсон:

Хурлын дарга: А. Баттамир

ТУЗ-ийн гишүүн: Н. Улаанхүү, Л. Тэмүүлэл

Гүйцэтгэх захирал: Б. Тамир

Хурлын тооллогын комисс: Л. Цэрэн-Очир, Т. Болорчимэг

Хурал зохион байгуулах комисс: Б. Ариунзул, Э. Онон

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах

ХУРЛЫН ИРЦ:

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 21,064,144 ширхэг хувьцааг эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч, 90,881 ширхэг хувьцааг эзэмшдэг 24 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон буюу 61.04%-ийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөрт тооцогдов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хурлын дарга А. Баттамир хурлын дэгийг танилцуулж, тооллогын комиссын дарга Л. Цэрэн-Очир хурлын ирцийг танилцуулж хурлыг хүчин төгөлдөр эхэлж байгааг мэдэгдснээр хурал эхлэв.

Гүйцэтгэх захирал Б. Тамир компанийн ерөнхий танилцуулга, дотоодын зах зээлийн судалгаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, борлуулалтын талаар болон 2018 оны төлөвлөгөө, хүрэх үр дүнгийн тухай танилцуулав.

Аудитын хорооны гишүүн Н. Улаанхүү 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулж, мөн ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

- Н. Улаанхүү: 2017 онд Айтүүлс ХК төлөвлөгөөнийхөө дагуу ажиллаж хөрөнгө босгосон, модуляр дата төвийн ажлыг эхлүүлсэн. Санхүүгийн хувьд борлуулалтын орлогоо 181% буюу 2.8 дахин нэмэгдүүлсэн, цэвэр ашиг 282%